



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А/32

Мандалговь

“Газар усны нэр тодруулах ажил”
(Багц-2 Гурвансайхан, Өндөршил сум)
зөвлөх үйлчилгээний ажил хүлээлцэх
комисс томилох тухай

Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 11.4, 16.3 дугаар заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн “Газар усны нэр тодруулах ажил”-ын Багц-2 болох Гурвансайхан, Өндөршил суманд зөвлөх үйлчилгээний ажлыг хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	Э.Чагнаадорж (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга)
Нарийн бичгийн дарга:	Д.Түвшинбаяр (“Дижитал Мэппинг” ХХК-ний гүйцэтгэх захирал)
Гишүүд:	О.Мөнхзул (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн) Ж.Элбэгзаяа (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Геодези зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн) Т.Уранбайгаль (Архивын тасгийн дарга)

2. “Газар усны нэр тодруулах ажил”-ын Багц-2 болох Гурвансайхан, Өндөршил суманд зөвлөх үйлчилгээний ажлыг хүлээн авч, холбогдох баримт бичгийг бүрдүүлэн ажиллахыг комиссын дарга (Э.Чагнаадорж)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  Л.ДОРЖБАТ



486210186